



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/86/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenkhamg@audit.gov.mn</p>
-------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөнчөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 178

танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.АРИУНАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хутаг-Өндөр сумын Уньт, Хантай багийн сургууль төсвийн шууд захирагч буюу төсвийн байгууллага биш байхад багийн төвийн сургуулиар тооцож, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг илүү тооцож олгосон байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад "Хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал" батлагдаж боловсролын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд зарцуулдаг болсон байна.

Аудитын гол асуудал

Уньт, Хантай багийн сургууль Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 дэх хэрэгжүүлээгүй, сумын төвийн Ерөнхий боловсролын сургуулиас тусдаа бие даасан санхүүгийн тайланг төсвийн шууд захирагчаар бэлтгэж ирүүлсэн байна.

006020210

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	132,757,070.33	179,314,058.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,739,300.00	49,870,058.99
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,739,300.00	49,870,058.99
3121	Төгрөг	2,739,300.00	49,870,058.99
31211	Төрийн сангийн харилцах	2,739,300.00	49,870,058.99
33	АВЛАГА	29,596,497.98	1,435,343.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	11,230,220.43	-
335	Бусад авлага	18,366,277.55	1,435,343.00
3351	Байгууллагаас авах авлага	14,366,277.55	1,435,343.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,000,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	100,421,272.35	128,008,656.35
354	Хангамжийн материал	100,421,272.35	128,008,656.35
35410	Бичиг хэргийн материал	5,810,660.00	6,399,960.00
35420	Аж ахуйн материал	44,334,610.45	57,950,280.45
35430	Сэлбэг хэрэгсэл	41,000.00	5,116,200.00
35440	Түлш, шатах тослох материал	253,999.99	465,763.99
35460	Хүнсний материал	42,000.00	2,212,450.00
35470	Бусад хангамжийн материал	49,939,001.91	55,864,001.91
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,793,655,499.35	2,854,314,712.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,793,655,499.35	2,854,314,712.96
392	Биет хөрөнгө	2,734,428,332.67	2,795,203,046.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,745,344,958.41	5,750,644,958.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,318,865,650.13)	(3,513,537,348.33)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	42,500,000.00	42,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,180,555.56)	(5,902,777.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	259,136,878.56	364,332,634.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(140,163,641.06)	(170,388,512.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,581,149.38	363,867,717.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(58,804,849.93)	(84,379,695.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	60,086,014.83	62,086,014.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	(34,053,188.03)	(42,003,161.16)
39217	Ном	26,847,216.20	27,983,216.20
393	Биет бус хөрөнгө	59,227,166.68	59,111,666.68
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(221,833.32)	(337,333.32)
39303	Бусад биет бус хөрөнгө	58,294,000.00	58,294,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,926,412,569.68	3,033,628,771.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	561,000.00	561,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	561,000.00	561,000.00
413	Өглөг	561,000.00	561,000.00

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	561,000.00	561,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,925,851,569.68	3,033,067,771.30
51	Засгийн газрын хувь оролцоо	2,925,851,569.68	3,033,067,771.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	981,093,711.45	981,093,711.45
51101	Өмч: - төрийн	981,093,711.45	981,093,711.45
512	Хуримтлагдсан үр дүн	544,906,968.91	652,123,170.53
51210	Өмнөх үеийн үр дүн	544,906,968.91	533,576,748.48
51220	Тайлант үеийн үр дүн	-	118,546,422.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,399,850,889.32	1,399,850,889.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,926,412,569.68	3,033,628,771.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,888,467,426.11	2,387,827,363.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	236,419,594.11	254,921,814.00
120	Нийтлэг татварын бус орлого	236,419,594.11	254,921,814.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,292,550.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,292,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,652,047,832.00	2,132,905,549.44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,214,278,500.00	1,645,834,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,214,278,500.00	1,645,834,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,936,318.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,966,318.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,970,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	388,833,014.00	487,071,349.44
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	388,833,014.00	487,071,349.44
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,855,687,961.40	2,269,280,941.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,855,687,961.40	2,269,280,941.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,814,459,525.15	2,182,507,571.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	942,534,592.10	1,194,776,549.59
210101	Үндсэн цалин	608,616,684.35	968,828,100.65
210102	Нэмэгдэл	265,493,284.79	172,113,019.78
210104	Урамшуулал	68,424,622.96	53,835,429.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,509,800.00	142,075,940.13
210201	Тэтгэврийн даатгал	86,979,900.00	100,259,394.40
210202	Тэтгэмжийн даатгал	8,973,700.00	10,366,709.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,398,400.00	8,890,716.40

210204	Ажилгүйдлийн даатгал	1,821,600.00	1,856,597.57
210205	Эрүүл мэндийн даатгал	18,336,200.00	20,702,521.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	389,239,814.01	396,752,019.28
210301	Гэрэл, цахилгаан	10,191,294.00	17,054,563.28
210302	Түлш, халаалт	370,548,520.01	373,297,456.00
210303	Цэвэр, бохир ус	8,500,000.00	6,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,511,025.00	3,273,450.00
210401	Бичиг хэрэг	2,210,330.00	74,050.00
210402	Тээвэр, шатахуун	3,697,300.00	3,154,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	147,475.00	-
210404	Ном, хэвлэл	64,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,104,800.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,287,120.00	-
2105	Нормативт зардал	63,614,570.00	117,424,036.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,067,800.00	-
210502	Хоол, хүнс	60,230,470.00	117,424,036.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,316,300.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,690,200.00	9,071,160.00
210604	Урсгал засвар	8,690,200.00	9,071,160.00
2107	Томилолт, зочны зардал	614,000.00	-
210702	Дотоод албан томилолт	614,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,153,760.00	2,705,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,153,760.00	2,705,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	272,591,764.04	316,429,216.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,463,750.00	40,970,456.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,526,618.00	12,199,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	256,601,396.04	263,259,110.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,228,436.25	86,773,370.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,016,260.00	86,773,370.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,216,260.00	86,773,370.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,212,176.25	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,212,176.25	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	32,779,464.71	118,546,422.05
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,028,279.17	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,028,279.17	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(5,028,279.17)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	27,751,185.54	118,546,422.05

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,666,382,652.00	2,144,098,099.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,334,820.00	11,192,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,334,820.00	11,192,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,334,820.00	11,192,550.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,334,820.00	11,192,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,662,047,832.00	2,132,905,549.44
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,214,278,500.00	1,645,834,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,214,278,500.00	1,645,834,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,936,318.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,966,318.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,970,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	388,833,014.00	487,071,349.44
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	388,833,014.00	487,071,349.44
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,604,680,992.00	2,027,648,840.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,604,680,992.00	2,027,648,840.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,566,827,215.75	1,934,290,270.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	942,773,898.75	1,189,727,779.82
210101	Үндсэн цалин	615,202,476.12	897,301,955.93
210102	Нэмэгдэл	259,146,799.67	232,116,633.33
210104	Урамшуулал	68,424,622.96	60,309,190.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	123,509,800.00	147,664,475.35
210201	Тэтгэврийн даатгал	86,837,400.00	101,244,634.72
210202	Тэтгэмжийн даатгал	9,116,200.00	11,734,212.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,386,300.00	9,699,420.40
210204	Ажилгүйдлийн даатгал	1,833,700.00	2,271,382.26
210205	Эрүүл мэндийн даатгал	18,336,200.00	22,714,825.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	387,692,014.00	393,495,783.28
210301	Гэрэл, цахилгаан	10,191,294.00	17,054,563.28
210302	Түлш, халаалт	369,000,720.00	370,041,220.00
210303	Цэвэр, бохир ус	8,500,000.00	6,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,622,623.00	45,000.00
210401	Бичиг хэрэг	1,751,418.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,652,300.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	461,655.00	-

210404	Ном, хэвлэл	501,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,848,650.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,407,400.00	-
2105	Нормативт зардал	67,819,850.00	117,595,046.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	784,900.00	-
210502	Хоол, хүнс	64,481,450.00	117,595,046.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,553,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,700,000.00	21,697,660.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	-
210604	Урсгал засвар	1,700,000.00	21,697,660.00
2107	Томилолт, зочны зардал	614,000.00	-
210702	Дотоод албан томилолт	614,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,440,560.00	7,528,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,440,560.00	2,705,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,822,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,654,470.00	56,536,526.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,532,900.00	41,568,076.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,121,570.00	14,968,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,853,776.25	93,358,570.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,641,600.00	93,358,570.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,841,600.00	93,358,570.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,212,176.25	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,212,176.25	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	61,701,660.00	116,449,258.99
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	63,433,060.00	69,318,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	63,433,060.00	69,318,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	63,433,060.00	69,318,500.00
222001	Тоног төхөөрөмж	17,369,200.00	67,318,500.00
223001	Бусад хөрөнгө	46,063,860.00	2,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(63,433,060.00)	(69,318,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1,731,400.00)	47,130,758.99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,470,700.00	2,739,300.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,739,300.00	49,870,058.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	517,155,783.37	2,898,100,384.14
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	517,155,783.37	2,898,100,384.14
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	27,751,185.54	27,751,185.54
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	544,906,968.91	2,925,851,569.68
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	544,906,968.91	2,925,851,569.68
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(11,330,220.43)	(11,330,220.43)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	533,576,748.48	2,914,521,349.25
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	118,546,422.05	118,546,422.05
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	981,093,711.45	1,399,850,889.32	652,123,170.53	3,033,067,771.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,144,098,099.44	2,096,967,340.45	47,130,758.99	97.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,144,098,099.44	2,096,967,340.45	47,130,758.99	97.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,231,905,199.44	1,191,574,625.82	40,330,573.62	96.7
210101	Үндсэн цалин	935,195,499.44	878,242,842.93	56,952,656.51	93.9
210102	Нэмэгдэл	270,310,700.00	253,022,592.33	17,288,107.67	93.6
210104	Урамшуулал	26,399,000.00	60,309,190.56	(33,910,190.56)	228.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,839,600.00	147,307,827.35	6,531,772.65	95.8
210201	Тэтгэврийн даатгал	104,611,100.00	101,244,634.72	3,366,465.28	96.8
210202	Тэтгэмжийн даатгал	12,307,000.00	11,377,564.87	929,435.13	92.4

210203	ҮОМШӨ-ний даатгал	9,845,700.00	9,699,420.40	146,279.60	98.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2,461,300.00	2,261,875.47	199,424.53	91.9
210205	Эрүүл мэндийн даатгал	24,614,500.00	22,724,331.89	1,890,168.11	92.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	396,200,000.00	394,195,783.28	2,004,216.72	99.5
210301	Гэрэл, цахилгаан	14,000,000.00	17,054,563.28	(3,054,563.28)	121.8
210302	Түлш, халаалт	373,700,000.00	370,741,220.00	2,958,780.00	99.2
210303	Цэвэр, бохир ус	8,500,000.00	6,400,000.00	2,100,000.00	75.3
2104	Хангамж, бараа материалын зардал	45,000.00	45,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,000.00	45,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	111,022,200.00	111,022,160.00	40.00	100.0
210502	Хоол, хүнс	111,022,200.00	111,022,160.00	40.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,700,000.00	21,697,660.00	2,340.00	100.0
210604	Урсгал засвар	21,700,000.00	21,697,660.00	2,340.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,550,300.00	14,537,000.00	13,300.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,705,200.00	2,705,200.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,845,100.00	11,831,800.00	13,300.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,861,500.00	116,655,828.00	(1,794,328.00)	101.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	97,093,800.00	98,888,878.00	(1,795,078.00)	101.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,767,700.00	17,766,950.00	750.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,974,300.00	99,931,456.00	42,844.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,974,300.00	99,931,456.00	42,844.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	99,974,300.00	99,931,456.00	42,844.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,144,098,099.44	2,096,967,340.45	47,130,758.99	97.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,645,834,200.00	1,598,703,441.01	47,130,758.99	97.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,645,834,200.00	1,645,834,200.00	-	100.0

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	487,071,349.44	487,071,349.44	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	487,071,349.44	487,071,349.44	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,192,550.00	9,899,950.00	1,292,600.00	88.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,192,550.00	9,899,950.00	1,292,600.00	88.5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	75.00	75.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	49.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	25.00	25.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй болно.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь бага, дунд боловсролын тухай хуульд заасны дагуу хамрах тойргийн хүүхдүүдийг бүрэн хамруулж чанартай боловсрол эзэмшүүлэх чиг үүрэгтэйгээр ажилласан байна.

2022 онд “Хүүхэд бүрийн суралцах онцлог, хөгжил, төлөвшилд нийцүүлэн тулгарч буй бэрхшээлийг багасгах замаар багшийн хөгжлийг дэмжиж, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагааг сайжруулах” зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хамрах тойргийн хүрээний хүүхэд нэг бүрийг чанартай бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх
- Хүүхэд бүрийг чанартай боловсрол эзэмшихэд туслан эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэн ажиллах
- Багшийн хөгжлийг дэмжиж сургуулийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 968 суралцагчтай, 87 багш ажилтантай ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдан 2022 оны 5 сараас зарим заалтууд нь хэрэгжиж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2022 онд сургуулийн захирлын тушаалаар дотоод хяналтын баг нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

БСШУЯ-аас гаргасан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Боловсролын салбарт болон өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон НБББББ батлаагүй, аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 107,765.2 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,739.3	50,419.20	47,679.90
Авлага	29,596.50	1,435.30	(28,161.20)
Бараа материал	100,421.30	128,008.60	27,587.30

Үндсэн хөрөнгө	2,793,655.50	2,854,314.70	60,659.20
Нийт хөрөнгө	2,926,412.60	3,034,177.80	107,765.20
Өр төлбөр	561.00	561.00	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,925,851.60	3,033,616.80	107,765.20
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,926,412.60	3,034,177.80	107,765.20

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь авлага, үндсэн хөрөнгийн данснууд буурсан байна.

Мөнгөн хөрөнгийн өсөлт нь Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор үлдэгдэл санхүүжилтийг төсвийн дансанд үлдээсэн, ажилчдаас авах авлагыг төлүүлснээс авлага буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсвөөс 1,833,548.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 187,714.0 сая төгрөгөөр бууруулж, 1,645,834.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй, мөн Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолд заасны дагуу хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлдэг зэргээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улс болон орон нутгийн төсвөөс 2,151,583.3 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,099,706.6 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 51,876.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	код	хөтөлбөр арга хэмжээний нэр				
1	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	4,738.1	4,737.3	0.8	100.0
2	80312	Сургалт, семинар	2,369.0	2,362.0	7.0	99.7
3	81605	Эрүүл мэндийн дэмжих	5,448.8	5,356.0	92.8	98.3
4	81801	Үдийн цай хөтөлбөр	99,974.3	99,931.5	42.8	100.0
5	81806	Дотоор байрны үйлчилгээ	146,167.5	143,440.5	2,727.0	98.1
6	81816	"Зөв монгол хүүхэд" үндэсний хөтөлбөр	55,445.0	55,445.0	-	100.0
7	81823	Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	10,660.6	10,659.0	1.6	100.0
8	81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,175,150.1	1,130,456.0	44,694.1	96.2

/мянган төгрөгөөр/

9	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	145,880.8	145,418.6	462.2	99.7
10	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчин сайжруулах	4,180.0	4,180.0	-	100.0
11	81848	Сурах бичгийн түрээс	3,997.8	2,705.2	1,292.6	67.7
12	83603	Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан	3,014.7	3,014.7	-	100.0
13	80111	Төрийн өмчит барилгын тогтмол зардал	417,900.0	415,893.4	2,006.6	99.5
14	80112	Нийтлэг үйлчилгээ	69,178.0	69,177.9	0.1	100.0
15	81834	Ахмадын сан	7,478.6	6,929.5	549.1	92.7
НИЙТ ДҮН			2,151,583.3	2,099,706.6	51,876.7	97.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад газраас худалдан авдаг байдлыг зогсоож хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 2,037,483.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 20,374.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15,281.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг 8 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 03/33 дугаар албан тоотоор ирүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	15,435.0	3	15,435.0	100.0
Албан шаардлага	2	33,915.0	2	33,915.0	100.0
Зөвлөмж	2	1,617.8	2	1,617.8	100.0
Нийт дүн	7	50,967.8	7	50,967.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайлан, Мөн Уньт, Хантай багийн сургууль Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, сумын төсвийн Ерөнхий боловсролын сургуулиас тусдаа бие даасан санхүүгийн тайланг төсвийн шууд захирагчаар бэлтгэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,463,100.8 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад нийт 1,463,100.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тайланд 39201, 39207, 39205, 39214, 39215 дансанд 185 нэр төрлийн хөрөнгийн элэгдлийн зардал бодоогүй байна.
- Үндсэн хөрөнгийн орлогыг ерөнхий журналаас тулган баталгаажуулахад акталсан 12 нэр төрлийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн орлогод бүртгэж, тайлагнасан.

Аудитаар нийт 687,544.2 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 222,004.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 465,539.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Тооцоолсон цалингаар цалингийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар НДШ, ХХОАТ, бусад өглөгийг бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.60 дахь заалттай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам-ын 4.2.1.1 "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага хүргүүлэх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайланд 39201, 39207, 39205, 39214, 39215 дансанд 185 нэр төрлийн хөрөнгийн элэгдлийн зардал бодоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэн, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бичиг хэрэг, Бусад хангамжийн материал, Аж ахуйн материалын дансанд тайлант хугацаанд шаардахаар гарсан боловч нярвын тайланд зарцуулагдаагүй материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-т заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Материалыг зарлагдахдаа эхэлж авснаа эхэлж зарлагдах аргаар зарцуулж хэвших.

3. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хутаг-Өндөр сумын Уньт, Хантай багийн сургууль төсвийн шууд захирагч буюу төсвийн байгууллага биш байхад багийн төвийн сургуулиар тооцож, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал”-ын 4 дүгээр хавсралтад заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүжилтийг батлагдсан тогтоолын дагуу нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаар авч, санхүүгийн нэг тайлан бэлтгэж, хэрэглэгчийг үнэн зөв мэдээллээр хангаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн тайланд 185 нэр төрлийн хөрөнгийн элэгдлийн зардал бодоогүй байна.	1	1,451,171.9			1	1,451,171.9						
Акталсан 12 нэр төрлийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн орлогод бүртгэж, тайлагнасан.	1	11,928.8			1	11,928.8						
Дүн	1	1,463,100.8			1	1,463,100.8						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тооцоолсон цалингаар цалингийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар НДШ, ХХОАТ, бусад өглөгийг бүртгэсэн.	1	222,004.9	-	-	1	222,004.9	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн тайланд 39201, 39207, 39205, 39214, 39215 дансанд 185 нэр төрлийн хөрөнгийн элэгдлийн зардал бодоогүй байна.	1	48,433.4	-	-	-	-	1	48,433.4	-	-	-	-
Бичиг хэрэг, Бусад хангамжийн материал, Аж ахуйн материалын дансанд тайлант хугацаанд шаардахаар гарсан боловч няравын тайланд зарцуулагдаагүй материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна.	1	70,708.2	-	-	-	-	1	70,708.2	-	-	-	-
Төсвийн шууд захирагч буюу төсвийн байгууллага биш байхад Уньт, Хантай багийн сургуулийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг илүү тооцож санхүүжилт авсан байна.	1	346,397.7	-	-	-	-	1	346,397.7	-	-	-	-
Дүн	3	687,544.20	-	-	1	222,004.90	2	465,539.30	-	-	-	-